

ЦАХИМ ШУУДАНД

НЭГТГЭЛИЙНХНИЙ СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛНЭ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл 2020-2021 оны сургуулийн жилд "Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах заавар"-ын хүрээнд цөөнгүй ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тухайлбал, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд сахилгын зөрчилгүй тэргүүний алба, салбар шалгаруулах болзолт уралдаан, мэдээлэл сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажлаар манлайлагч рот, батарей шалгаруулах уралдаан, үндсэн салбаруудын дунд тэргүүний тохижилттой соёл амралтын танхим шалгаруулах уралдааныг тус тус зарлан, сар бүр дүгнэж байна. Мөн хээрийн гаралт, полигоны дадлагын үеэр хээрийн ухуулах байр, ухуулах цэгийг дэлгэн салаа бүрт сайн дурын идэвхтэн ухуулагч томилон, сурган зааварлах

хичээлийг явуулсан нь сэтгэл зүйн хангалтын ажлыг зохион байгуулахад чухал ач холбогдолтой үр дүнгээ өгсөн ажил, арга хэмжээ болж чадсан юм.

Ухуулагчийн тэмдэгтэй цэргүүд сургууль, дадлага явагдаж байгаа цэгүүдэд явуулын ухуулах цэг дэлгэж, тухайн өдрийн мэдээллийг агуулсан "Их булаг" сониныг бэлтгэн хэвлэж, тараах материалын хамт түгээж, яриа таниулга, сурталчилгааны ажлыг тасралтгүй зохион байгуулав. Мөн урлаг соёлын арга хэмжээ хөтөлбөрийн дагуу явагдсан бөгөөд оройн цагаар хөгжөөнт тоглоом, уралдаан тэмцээнүүдийг байлдааны нөхцөлд ойртуулсан хэлбэрээр явуулсан нь онцлог байлаа. Түүнчлэн сургалтын материал хэвлэх хэвлэлийн машин бусад шаардлагатай материал хэрэгслийг худалдан авч, хэвлэлийн цехийн үйл ажиллагааг эхлүүлсэн юм. Сургалтад ашиглах сэтгэл зүйн бэлтгэл, хуулийн гарын авлага,

уриалга, санамж, зөвлөгөө, дайчин хуудас, ухуулах хуудас болон бусад үзүүлэн таниулах материал зэрэг 150 гаруй материалыг сайн дурын ухуулагч нараар дамжуулан, бие бүрэлдэхүүнд хүргэлээ. Түүгээр зогсохгүй дүрс, дуу бичлэгийн студийг нөөц бололцоондоо тулгуурлан ажиллуулж, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан нэгтгэлийн үйл ажиллагааг сурталчилсан шторк, хугацаат цэргийн алба хаагчдын мэндчилгээ, яруу найрагч Д.Пүрэвдоржийн "Тусгаар тогтнол" шүлгээр хийсэн баярын мэндчилгээг дүрсжүүлэн олон нийтийн хүртээл болгов.

Тасаг, салааны байлдааны буудлага, хоногийн сургууль, рот, батальоны байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг явуулах талаарх видео хичээлийг бэлтгэн, ХЗЦК-ын нэгтгэл, ангиудад ашиглуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Даргалах албан тушаалын ахлагч, салаа, ротын



захирагч, батальон, дивизионы захирагч нар болоод албадын дарга нарын хийх ажил үүргийн хуваарийг өдөр, долоо хоног, сар, улирал, хагас жил, бүтэн жилээр нь төлөвлөн бодит үзүүлэнгийн

самбар хэлбэрээр гаргаж I, II штабт байрлуулан мөрдлөг болгон ажиллаж байна.

Хошууч Д. ДОЛГОРСҮРЭН

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙНХЭН "ИЛГЭЭМЖ" АЯН



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран уулзалтыг угсан холбоо болон интернэтээр зохион байгуулсаар байна.

Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийнхан цахим уулзалтаас гадна "Цэрэг эрсэд хүргэх таны илгээмж" аяныг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан хугацаат албаны дайчдын ар гэрийнхний дунд өрнүүлж байна. 2020 оны 12 дугаар

сараас эхлэн шинэ жил, Цагаан сар, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан илгээмжийг хүлээж авсан бөгөөд өдгөө хэрэгжээд хэвшил болжээ. Цар тахлын эрсдэлтэй энэ үед дайчдын эцэг эх, ар гэрийнхний сэтгэл шингэсэн илгээмж, захидал, гэрэл зургууд зүүн хязгаар Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгаас эзэндээ тогтмол ирсээр байгаа юм. Хамгийн сүүлийн жишээ гэхэд байлдагч Э.Лхасүрэн илгээмжээр гэрээсээ унших дуртай боть номоо захиалж авчруулсан байна.

ЭЦЭГ ЭХЧҮҮД ЦАХИМААР ХОЛБОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАНД ТАЛАРХАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

2020 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар дүүрэг болон Дархан-Уул аймгаас татагдан Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хааж

байгаа дайчдыг ар гэрийнхэнтэй нь цахимаар "уулзуулаа". Тус арга хэмжээнд оролцсон эцэг эхчүүд хөвгүүддээ алба нэр төртэй хаахыг захиад, цар тахлын нөхцөл байдлын улмаас үр хүүхдүүдээ эргэж тойрч чадахгүй байгаа энэ үед цахимаар холбох ажлыг зохион байгуулсанд талархал дэвшүүлсэн юм.

Д.Жамъяансүрэн: ЭЭЖИЙНХЭЭ МЭРГЭЖЛИЙГ ӨВЛӨЖ БАГШ БОЛНО

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Таны хүсэл мөрөөдөл, зорилго юу вэ гэдгээс ярилцлагаа эхлүүлье?

-Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие хугацаат цэргийн албанд татагдахаасаа өмнө МУИС-д Түүх, нийгмийн багш мэргэжлээр суралцаж байсан, хоёрдугаар дамжааны оюутан. Өөрийгөө тодорхойлооч гэвэл багш хүний үр удам гэж хэлнэ. Миний гэр бүл, ах дүү, хамаатан садны олонх нь сурган хүмүүжүүлэгч, багш мэргэжилтэй хүмүүс. Үүгээрээ ч би бахархдаг. Тэднийхээ залгамж халааг авч сайн багш болох нь миний мөрөөдөл.

Аль нутгийнх билээ?

-Увс аймгийн Тэс сумынх. 2001 оны 7 дугаар сарын 1-нд Н.Дамжингийн ууган хүү болж мэндэлсэн. Манай сумын онцлог хурдан морь, хүчит бөх юм.

Багшийн удамтай гэлээ. Бидэнд энэ талаараа дэлгэрүүлж ярихгүй юу?

-Миний ээжийг Доржийн Чулуун гэдэг, бага ангийн багш мэргэжилтэй. Увс аймгийн Тэс суманд 20 гаруй жил багшилсан, олон мянган шавьтай. Удахгүй гавьяаныхаа амралтад гарна. Ээжийн дүү Д.Одон эгч маань ч ялгаагүй сурган хүмүүжүүлэгч. Эдгөө "Эрдмийн ундраа" цогцолбор сургуульд математикийн багшаар ажилладаг бол авга эгч Н.Буян Увс аймгийн Тэс сумандаа түүх, нийгмийн ухааны багшаар ажиллаж байна. Айлын ууган хүү гэдэг угтаараа гэр бүлийнхээ эрхэм болсон мэргэжлийг өвлөж, ээж шигээ олон аавын хүү, ээжийн охинд эрдэм заах багш хэмээх сайхан мэргэжлээр суралцаж байгаадаа бахархаж явдаг.

Та ном унших их дуртай гэсэн. Чөлөөт цагаараа ангийн номын сангийн номуудыг дуусгасан биз?



-Тийм ээ. Багшийн хүүхэд учир ийм байхаас ч аргагүй. Уншсан ном гэвэл тоймгүй их. Тэр дундаа одоо ч зохиолын гол дүр нь санагддаг бүтээлүүд гэвэл "Усан доогуур 20000 бээр аялсан нь", "Дэлхийн төв рүү аялсан нь", "Дэлхийгээс сар хүртэл", "Робинзон Крузо", "1001 шөнийн үлгэр", "Чонон сүлд" юм. Бага байхад ээж маань "Ном бол ертөнцийг харах цонх юм. Чи өөрийнхөө мэдэхийг хүссэн асуулт болгоныхоо харилуулгыг номоос олж болно" гэж үргэлж хэлдэг байсан.

Цэргийн албанд ирснээр сэтгэгдэл ямар байна вэ?

-Миний хувьд олон дадал, зуршлыг өөртөө бий болгосон. Анх ирэхдээ өөрийгөө илэрхийлэх талаар жаахан дутмаг, бүрэг ичимхий байсан. Цэргийн албанд татагдсанаар хувь хүн талаасаа ахиц дэвшил нилээдгүйг авчирсаны нэг нь хамт олонч, нийтэч байдал юм. Бас аливаа зүйлийг хойшлуулалгүй цаг тухайд нь хийж сурсан. Цэргийн

алба нь өөрөө онцлогтой бөгөөд хүнд тэсвэр тэвчээр, хатуужил цаашлаад хүнээс үг сонсож сурах, би бүгдийг чадна гэх итгэлийг маш ихээр суулгаж өгсөн.

Үе тэнгийнхээ залууст хандаж юу хэлэх вэ?

-Миний хувь хүний хөгжил, эзэмших гэж буй мэргэжил, ойрын болон холын зорилго, мөрөөдөл гэх эдгээр том хүчин зүйлүүдийг хөдөлгөх гол хүч нь зөв хандлага юм. Тэр ч угтаараа залуусыг номтой нөхөрлөж, олон талын судалгаа хийж, өөрийгөө тогтмол хөгжүүлэх тал дээр анхаарч, аливаа зүйлд ул суурьтай хандаж байгаасай гэж хүсье. Залуучууд маань бие биедээ эерэг хандлагыг түгээж, зөв үлгэрлэн, нөлөөлөл үзүүлж байгаасай. Хар бараан яриа, шүүмжлэлээрээ бусдыг будахын оронд сэтгэлийн дэм, урмаар усалж яваарай гэе.

Дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

Ковид-19!!! Бага насны хүүхдтэй эцэг эх, асран хамгаалагчдад өгөх зөвлөгөө

COVID-19 халдвараас сэргийлэх:

- Бага насны хүүхдийг олон нийтийн газраар дагуулж явахгүй байх
- Хүүхэд олноор цугласан тоглоомын талбайд тоглуулахгүй байх
- Зайлшгүй гэрээс гарах тохиолдолд маск зүүх, 2 цагаас дээш хугацаанд маскыг солих, гарыг угаах, халдваргүйжүүлэх
- Гэртээ өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийж, 3-4 удаа агааржуулалт хийх
- Хүүхдийн аяга, таваг, халбага хэрэгслийг солихгүй байх
- Хүүхдийн тоглоомыг сода, давстай халуун усаар угааж цэвэрлэх
- Хүүхдийн гар нүүрийн алчуур, цагаан хэрэглэлийг угааж индүүдэх
- Гурван цаг тутамд халуун хоол, цай хэрэглүүлэх



- Хөдөлгөөний идэвхийг дэмжиж, чийрэгжүүлэх
- Аливаа дэлгэц (ТВ, гар утас)-ийг нэг дор 30 минутаас илүү үзүүлэхгүй байх
- Оройн 21 цагт унтуулж сурах

Бусад цочмог өвчнөөс сэргийлэх:

- Хаврын улиралд дулаан хувцаслах
- Даарснаас үүдэлтэй амьсгалын замын цочмог халдвар (ханиалгах, халуурах, хоолой өвдөх)-аас сэргийлэх
- Угаартахаас сэргийлэх
- Бага насны хүүхдийг аливаа бодис (эм, цэвэрлэгээний бодис, цавуу)-ын хордолтоос сэргийлэх
- Гаднын биет (батарей, жижиг тоглоом, самар, шүр)-ийг залгих, хамар, чихэнд хийхээс сэргийлэх
- Гурван хүртэлх насны хүүхдэд Д аминдэмийг зохих тунгаар уулгах